



**“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**“Шивээ-Овоо” ХК-ийн 2017 оны
үйл ажиллагааны тайланг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 болон “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.10.4 дэх заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Шивээ-Овоо” ХК-ийн 2017 оны үйл ажиллагаанд Төлөөлөн удирдах зөвлөлөөс хийсэн дүгнэлтийг зөвшөөрч, компанийн 2017 оны үйл ажиллагааг хангалттай гэж баталсугай.

ДАРГА  О.ОДБАЯР





**“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

┌ “Шивээ-Овоо” ХК-ийн 2017 оны санхүүгийн
тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 болон “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.10.4 дэх зүйлийг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Шивээ-Овоо” ХК-ийн санхүүгийн тайлан тэнцлийн дүн, түүнд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. “Шивээ-Овоо” ХК-ийн 2017 оны жилийн эцсийн тайлангийн нийт хөрөнгийн дүнг 116,195,697,193.24 төгрөг. Үүнээс:

- А. Эргэлтийн хөрөнгийг 21,947.1 сая төгрөг
- Б. Эргэлтийн бус хөрөнгийг 94,248.6 сая төгрөгөөр
- В. Урт хугацааны хөрөнгө оруулалтыг 0 төгрөгөөр
- Г. Урт хугацаат өр төлбөрийг 46,359.3 сая төгрөгөөр
- Д. Төрийн өмчийн дүнг 1,207.7 сая төгрөгөөр
- Е. Эзэмшигчдийн өмчийн бусад хэсгийг 0 сая төгрөгөөр
- Ё. Хувьцаа эзэмшигчдийн өмчийн дүнг 134.2 сая төгрөгөөр
- Ж. Хуримтлагдсан ашиг 5,261.8 сая төгрөгөөр
- 3. Богино хугацаат өр төлбөрийг 63,232.7 сая төгрөгөөр
- И. Тайлант үеийн ашгийг 240.5 сая төгрөгөөр тус тус баталсугай.

ДАРГА



О.ОДБАЯР



“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны
зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь зүйлийг үндэслэн
ТОГТООХ нь:

1. “Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны зардлын
төсвийг **110,437.6** сая төгрөгөөр тогтоож, хавсралтын дагуу баталсугай.
2. Батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулахыг Төлөөлөн удирдах
зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



О.ОДБАЯР

Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 сарын 30-ны
өдрийн 03 дугаар тогтоолын хавсралт



ТУЗ-ийн гишүүдийн 2018 оны зардлын төсөв

Д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	2018 оны төсөв
1	Цалин хөлс НДШ	м.төг	90,309.6
2	Унааны зардал	м.төг	1,100.0
3	Хоолны зардал	м.төг	800.0
4	Томилолт	м.төг	1,728.0
5	Сургалт	м.төг	500.0
6	Бичиг хэрэг	м.төг	1,000.0
7	ХЭХ-ын бүртгэл судалгаа	м.төг	5,000.0
8	Бусад	м.төг	10,000.0
	Дүн	м.төг	110,437.6
1	Гишүүд	Хүн	9
2	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Хүн	1



**“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Компанийн эзэмшилд байгаа орон
сууцуудыг хувьчлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, “Орон сууц хувьчлах тухай хууль”-ийн 6.4, “Шивээ Овоо” ХК-ийн дүрмийн 11.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нэгдүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах “Шивээ-Овоо” ХК-ийн эзэмшилд байгаа 09, 10, 14, 15 тоот орон сууцнуудыг хувьчлах тухай “Шивээ-Овоо” ХК-ийн уурхайн ажилчдын гаргасан болон ҮЭХ-ны мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу эдгээр байрнуудыг ажилчиддаа хөнгөлөлттэй үнээр худалдах ҮЭХ-ны саналыг үндэслэн Гүйцэтгэх удирдлагуудын зүгээс гаргасан саналыг дэмжиж, эдгээр байруудыг хувьчилсугай.

2. “Орон сууц хувьчлах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх “Аудитын хороо” /Ц.Амартүвшин/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



О.ОДБАЯР



ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

1.1. Орон сууц хувьчлах журмын зорилго нь "Шивээ-Овоо" ХК-ийн нийтийн зориулалттай орон сууцыг хувьчлахад байгууллага, иргэний хоорондох үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Орон сууц хувьчлах журмын эрх зүйн үндэс нь Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Орон сууц хувьчлах тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

1.3. Хувьчлах үйл ажиллагааг "Шивээ-Овоо" ХК-ийн эрх барих дээд байгууллагаас гаргасан нийтийн зориулалттай орон сууцыг хувьчлах тухай шийдвэр, орон сууцны нэгж талбайг хувьчлах суурь үнэ болон эрх бүхий байгууллагаас гаргасан орон сууцны талбайн тодорхойлолтыг үндэслэн "Орон сууцны комисс" /цаашид комисс гэх/ зохион байгуулна.

2. Баримтлах зарчим

2.1. Орон сууц хувьчлахад нийтийн зориулалттай орон сууцны байшингийн /цаашид "орон сууц" гэх/ нэг сууц /өрөө/-ыг түүнийг эзэмшигчдэд тухайн орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгөөс ногдох хэсгийн хамт сайн дурын нь үндсэн дээр, зөвхөн орон сууцны зориулалтаар, хувьчлах ажлыг ил тод явуулах зарчмыг баримтална.

3. Хувьчлагдах орон сууц

3.1. "Шивээ-Овоо" ХК-ийн Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах, 9, 10, 14, 15 дугаарын угсармал бетон орон сууцны барилгууд хувьчлалд хамрагдана.

Хувьчлах орон сууц нь нийтийн зориулалттай орон сууцны стандарт нормыг хангасан байна.

4. Орон сууц хувьчлан авах эрх

4.1. Хувьчлах орон сууцыг орон сууц хөлслөх гэрээгээр эзэмшиж байгаа "Шивээ-Овоо" ХК-ийн ажилтан, тус компанитай хамтран ажилладаг төрийн болон харилцагч байгууллагын ажилтнууд хувьчлан авах эрхтэй.

4.2. Дээрх хувьчлах орон сууцнуудаас байгууллагын ажлын зайлшгүй хэрэгцээ шаардлагыг үндэслэн зохих тооны орон сууцыг "Шивээ-Овоо" ХК-ийн өмчлөлд хэвээр үлдээнэ.

5. Сууц хувьчлан авах иргэдийн эрх

5.1. Журмын 4.1-д заасан эрх бүхий иргэд орон сууц хувьчлан авах тухай өргөдлийг комисст гаргах;

5.2 Тухайн орон сууцны байшингийн талаар гарсан магадлан шинжилгээний хэсгийн дүгнэлт, орон сууцны талбайн тодорхойлолттой танилцах, тэдгээрийн талаархи гомдол, дахин хийлгэх тухай хүсэлтээ комисст гаргах;

5.3. Хуульд заасан бусад эрх;

6. Сууц хувьчлан авах иргэдийн үүрэг

6.1. Орон сууц хөлслөх гэрээ, иргэний бичиг баримтаа ямар нэг зөрчилгүй байлгах;

6.2. Орон сууцныхаа хөлсийг бүрэн төлсөн байх;

6.3. Орон сууцныхаа нийт болон сууцны талбайн тодорхойлолтыг комисст гаргаж өгөх;

6.4. Хувьчлан авсан сууцны төлбөрийг хугацаанд нь төлөх;

6.5. Банкны ипотекийн зээлийг авахад шаардагдах бичиг баримтыг бүрдүүлэх;

6.5. Хуульд заасан бусад үүрэг;

7. Хувьчлах сууцны талбайг тодорхойлох

7.1. Хувьчлах орон сууцны талбайг MNS: 6058:2009 “Орон сууцны барилгын доторхи сууцны талбай тодорхойлох аргачлал” стандартын дагуу мэргэжлийн эрх бүхий байгууллагаар тодорхойлуулна;

8. Хувьчлах сууцны үнэлгээ, түүнийг тодорхойлох талбай

8.1. Хувьчлах сууцны үнэлгээг талбайг орон сууцны талбайгаар тогтооно.

8.2. Хувьчлах орон сууцны үнэлгээг тогтоохдоо сууцны талбайг нэгж талбайн ерөнхий итгэлцлүүрийг суурь үнээр үржүүлнэ.

8.3. Хувьчлах сууцны нэгж талбайн суурь үнэ нь ... байна.

8.4. Хувьчлах сууцны үнэлгээнд дараахь итгэлцүүрийг хэрэглэж сууцны үнэлгээг тогтооно.

№	Үзүүлэлтүүд	Хэрэглэх итгэлцлүүр
1.	Байршил/Ашиглалтын хугацаа	
	- 9, 10 байр	1.00
	- 14, 15 байр	1.10

2.	Өмчилж авах эрх бүхий этгээд	
	- Компанийн ажилтнууд	1.00
	- Төрийн албан хаагчид	1.25
	- Харилцагч байгууллагын ажилтнууд	1.50

8.5. Хэд хэдэн итгэлцлүүр нэг зэрэг хэрэглэхээр байвал тэдгээрийг хооронд нь үржүүлж, ерөнхий итгэлцлүүр гаргаж хэрэглэнэ.

9. Сууц хувьчлах тухай шийдвэр гаргах

9.1. Комисс нь журмын 4.1-д заасан эрх бүхий иргэдийн өргөдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тухайн сууцыг хувьчлах нөхцөл хангагдсан эсэхийг хянаж, сууц тус бүрээр хувьчлах тухай шийдвэр гаргана.

9.2. Хувьчлах нөхцөл хангаагүй сууцны талаарх өргөдлийг сууц эзэмшигчид буцаах бөгөөд уг этгээд энэ журмын 6 дугаар зүйлд заасан үүргийг хангасны дараа дахин өргөдөл гаргах эрхтэй.

10. Үнэтэй хувьчлах сууцны үнийг төлөх хэлбэр, хугацаа

10.1. Үнэтэй хувьчлах сууцны үнийг дараахь хэлбэрээр төлнө:

10.1.1. бэлэн ба бэлэн бус мөнгөн хэлбэрээр;

10.1.2. Хувьчлах орон сууцны үнийг тухайн сууцыг хувьчлах тухай шийдвэр гарснаас хойш 1 сарын дотор банкнаас шаардсан бичиг баримтыг бүрдүүлж, ипотекийн зээл авах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна;

10.1.3. Хувьчласан орон сууцны үнийг 1 сарын хугацаанд төлөөгүй бол тухайн сууцыг хувьчлах тухай шийдвэр хүчингүй болно;

11. Өмчлөх эрхийн гэрчилгээ

11.1. Сууц хувьчлах тухай шийдвэрийг үндэслэн комисс акт үйлдэн орон сууцыг иргэдэд хүлээлгэн өгч өмчлөх эрхийг баталгаажуулна;

11.2. Компаниас нийтийн зориулалттай орон сууцыг хувьчлан авсан тухай шийдвэрийг үндэслэн иргэн Улсын бүртгэл, оюуны өмчийн ерөнхий газарт хандаж “Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ” авна;



**“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

┌ Ногдол ашиг хуваарилахгүй байх ┐
тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаарын зүйлийн 46.1, 46.2 дахь заалтуудыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. Тус компани нь 2017 оны санхүүгийн тайлангаар 240.5 сая төгрөгийн ашигтай ажилласан боловч богино хугацаат өр төлбөр өндөр, түүнийг барагдуулах эх үүсвэр дутмаг байгаа, дээрх ашиг нь хөрс хуулалтын зардлыг хойшлуулснаас үүссэн бодит бус ашиг үүссэн зэргийг харгалзан ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  О.ОДБАЯР





**“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

┌ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг
сонгох тухай ┐

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 болон “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.10.3 дэх заалт, 2018 оны 04 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг 1 дүгээр хавсралтаар, Хараат бус гишүүдийг 2 дугаар хавсралтаар 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн сонгосугай.

ДАРГА



О.ОДБАЯР

Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 сарын 30-ны
өдрийн 06 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралт



**“Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд
хувьцаа эзэмшигчдийг төлөөлөх гишүүд**

Д/д	Гишүүдийн нэр	Үндсэн ажил
1	О.Одбаяр	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн бизнес удирдлага хариуцсан дэд захирал
2	Д.Ганболд	ЗГХЭГ-ын зохион байгуулалтын газрын дарга
3	Б.Тэлмүүн	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга
4	Н.Болдхүү	Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг хангах газрын дарга
5	Д.Дамба	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ахлах мэргэжилтэн
6	Д.Даянбилгүүн	“БиДиСЕК ҮЦХ” ХК-ийн гүйцэтгэх захирал /Хувь нийлүүлэгчийн төлөөлөл/

Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 сарын 30-ны
өдрийн 06 дугаар тогтоолын 02 дугаар хавсралт



**“Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн хараат бус гишүүд**

Д/д	Гишүүдийн нэр	Үндсэн ажил
1	Ц.Амартүвшин	“Монгол Ураниум Ресурс” ХХК-ийн дэд ерөнхийлөгч
2	Г.Атармаа	“Өмгөөлөгчдийн холбоо”-нд өмгөөлөгч
3	Л.Цэцгээ	Дулааны инженер /тэтгэвэрт/